



94

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 66

Мандалговь

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сайнцагаан сумын Долоодугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 57,468,367 /тавин долоон сая дөрвөн зуун жаран найман мянга гурван зуун жаран долоо /төгрөгийн балансын үнэтэй, 54,712,767 /тавин дөрвөн сая долоон зуун арван хоёр мянга долоон зуун жаран долоон/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй цэвэр, бохир, дулааны шугамыг хавсралтын дагуу “Дундговь-Ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сайнцагаан сумын Долоодугаар цэцэрлэгийн эрхлэгч (Л.Дэлгэрмаа), “Дундговь-Ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга (Д.Ганбаатар) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 5 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 4 дүгээр сарын
28-ний өдрийн 6.6 тогтоолын хавсралт

Долоодугаар цэцэрлэгийн балансаас хөрөнгө шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Цэвэр усны шугам	2013.12.06	м	72.8	106,875.72	7,780,552.42	511,875	7,268,677.42
2	Бохир усны шугам	2013.12.06	м	69.34	207,180.75	14,365,913.38	945,128.40	13,420,784.98
3	Дулааны шугам	2013.12.06	м	67.2	525,623.54	35,321,901.89	1,298,596.35	34,023,305.54
Нийт дүн								
						57,468,367.69/	2,755,599.75 /хоёр	54,712,767.94 /
						тавин долоон сая дөрвөн зуун жаран найман мянга гурван зуун жаран долоо жаран есөн мөнгө/	сая долоон зуун тавин таван мянга таван зуун ерэн ес далан таван төгрөг/	тавин дөрвөн сая долоон зуун арван хоёр мянга долоон зуун жаран долоо ерэн дөрвөн мөнгө/